

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 20 -ны өдөр

Дугаар 20/01

Улаанбаатар хот

АПУ ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт эхлэв. Хурлыг Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо хороо, Махатма Гандийн гудамж 39, Корпорейт Хотел энд Конвеншн Цэнтрийн 4 давхарт байрлах Концертын танхимаас Компанийн цахим хуудсаар шууд дамжуулан явуулав.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан МУЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоолын дагуу Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулж хурлыг цахимаар хийж байгааг цохон тэмдэглээд, хурлын панелистууд болох хурлын дарга бөгөөд Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Батбаяр, Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг нарыг танилцуулан, 76001111 шууд утсаар сонирхсон асуултаа асуухыг хувьцаа эзэмшигчдээс хүслээ. Улмаар хурлын ирцийн мэдээг танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Б.Мягмарыг индэрт урив.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Б.Мягмарын танилцуулснаар:

Компанийн 1,014,277,394 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 165 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 1,062,974,743 ширхэг энгийн хувьцааны **95.42 хувь** болж байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь заалт, Компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хурлын хэлэлцэх асуудал болох Компанийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг танилцуулна уу хэмээн хурлын дарга Ц.Эрдэнэбилэгийг индэрт урив.

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурал цахимаар явагдаж байгаа ба энэ жил аудитлагдсан тайлангаа тавьж буй онцлогтойг дурдаад, Компанийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан болон 2020 оны зорилго, зорилтуудыг товч танилцуулав [танилцуулгыг хавсаргав].

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан 2019 оны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Батбаярыг индэрт урив.

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Батбаяр дэлхий нийтэд тархаад буй аюулт өвчнөөс сэргийлж амны хаалт хэрэглэн, гараа тогтмол угааж, олон нийтийн газраар явахгүй байхыг уриалаад, өнгөрөгч онд хичээнгүйлэн ажилласан Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгээр удирдуулсан Гүйцэтгэх удирдлагын баг, компанийн нийт ажилтан ажиллагсад, харилцагчид болон хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн нэрийн өмнөөс талархсанаа илэрхийлэв. Мөн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороонд харьяалагдан ажилладгийн хувьд Компанийн ТУЗ-ийн 2019 оны ажлын тайланг товч танилцуулахдаа өнгөрөгч онд 97%-ийн дундаж ирцтэйгээр нийт 11 удаа хуралдаж, 25 тогтоол шийдвэр гаргалаа гэв. Улмаар Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар **“АПУ групп компани 2019 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан”** хэмээн ТУЗ дүгнэж байгааг танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултуудад хариулт өгнө үү хэмээн хурлын дарга Ц.Эрдэнэбилэгт хувьцаа эзэмшигч П.Билгүүний асуултыг уламжлав.

Асуулт:

1. Цэвэр ашгийн өсөлтөд юу нөлөөлсөн бэ?
2. Ковид-19 цар тахал борлуулалтад сөргөөр нөлөөлж байна уу? Үүнтэй холбоотойгоор цаашид орон тооны цомхотгол хийх үү? Ажилчдыг цалинтай амраасан хэвээр байж чадах уу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг:

1. Компани 2019 онд амжилттай ажиллаж, ашигт ажиллагаа өссөн. Монгол Улсын эдийн засаг 2019 онд тогтвортой байж, томоохон эрсдэл гараагүйгээс гадна бид 2017 онд болсон нэгдлийн дараа стратегийн төлөвлөгөө гаргаж, групп компанийн зохион байгуулалт, хоорондын үйл ажиллагааг сайжруулах, зардал хэмнэх, менежментийн оновчтой бодлогыг барих, бизнесийн процессыг оновчжуулах чиглэлээр маш их ажил хийсэн нь ашиг нэмэгдэхэд нөлөөлсөн.
2. Дэлхий нийтэд Ковид-19 цар тахал тархаж, Монгол Улс өндөр эрсдэлтэйд тооцогдож байна. Бид эцсийн мөч хүртэл орон тооны цомхотгол хийхгүй байхад анхаарч, үйл ажиллагаа нь доголдож буй алба газруудын зардлын удирдлагыг сайжруулан ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд 300 гаруй ажилтнаа зайнаас ажиллуулах боломжоор хангасан. Ялангуяа Улаанбаатар хотод 3 дугаар сард олон тооны бар ресторан үйл ажиллагаагаа зогсоож, орон нутагт бүтээгдэхүүний борлуулалтыг хязгаарласантай холбоотойгоор борлуулалт их хэмжээгээр унаж байна.

Гэвч бид үйл ажиллагаа, хүнийн нөөцөө оновчтой төлөвлөж, боломжит эцсийн өдрийг хүртэл ажилтнуудаа цомхотгохгүйгээр үл барам ажилтнуудын хариуцлага, хувь хүний хөгжилд түлхүү анхаарч, эрч хүчтэй ажиллахаар төлөвлөж байна. Ковид-19-ийг бид нэг талаас засаглал, бизнесийн процесс, шийдвэр гаргалтыг сайжруулах сорилт, нөгөө талаас эх дэлхийдээ зэрэгцэн ажиллах боломж хэмээн дэнслэн харж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан санал хураалт эхэлж буй зарлан, санал өгөх зааврыг товч танилцуулав.

Санал хураалт явагдаж, дуусав.

Тооллогын комиссын дарга Б.Мягмар санал хураалтын дүнг танилцуулав:

“АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал болох 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах асуудлаар ердийн журмаар санал хураалт явуулахад хуралд оролцсон саналын эрхтэй нийт 1,014,277,394 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 165 хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноос 1,012,810,450 ширхэг хувьцаа эзэмшиж буй 65 хувьцаа эзэмшигч саналаа ирүүлсэн. Үүнээс:

Зөвшөөрсөн: **1,012,789,879** ширхэг хувьцаа буюу **99.99** (99.998) хувь,

Татгалзсан: **20,571** ширхэг хувьцаа буюу **0** (0.002) хувь,

Түдгэлзсэн: **0** ширхэг хувьцаа буюу **0** хувь эзэлж байна.

Иймд Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт, АПУ ХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8-д заасны дагуу АПУ ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах шийдвэрийг хүчин төгөлдөрт тооцов” гэв.

Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. АПУ ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

Ээлжит хурлыг хаав.

Хурал 15 цаг 10 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ч.Ариунсан

Ц.Эрдэнэбилэг